Хөхний булчирхайн гиперплазийн эмгэгт Хөхөн-1 эмийн үзүүлэх нөлөөг судалсан эмнэлзүйн судалгааны зарим үр дүн

Zhao Shuang Quan[1], Ч.Чимэдрагчаа[2], Ж.Жамбалдорж[3], Т.Алимаа[1]

[1]Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль. АШУҮИС,
[2]Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэн,
[3]Био Анагаахын Сургууль.АШУҮИС
Email: 13154898993@163.com, Утас:96655004

Түлхүүр үг:

Хөхөн-1
Хөхний булчирхайн гиперплази
Эмнэлзүйн туршилт судалгаа

Товч утга: Хөхний булчирхайн гиперплази өвчин нь Монгол анагаах ухааны онолоор эмэгтэйчүүдийн цус бүрэлдсэн өвчний нэг зүйл болох юм. Монгол эм, эмнэлгийн практикт (Өвөр Монгол) тус өвчнийг хөхөн-1 эмээр 30 гаруй жил эмнэн засаад үр дүн сайтай байна.Тиймээс бид хөхний булчирхайн гиперплазийн эмгэгийн үед Хөхөн-1 эмийн эмнэлзүйн судалгаа хийж үр дүнг тооцохоор сонгон авлаа. Судалгааг ӨМҮИС-ийн Харьяа Эмнэлгийн Хороог түшиглэн санамсаргүй хуваарьлалттай эмнэлзүйн туршилт судалгааны зэрэгцүүлсэн загвараар хийв. Судалгаанд хамруулах шалгуурын дагуу үйлчлүүлэгчийг сонгон авч судалгааны бүлэгт (n=40) монгол эм хөхөн-1, харьцуулах бүлэгт(n=40) хятад эм Xia Ku Cao хэрэглэн 3 ба 6 дахь долоо хоног бүр эмчилгээний үр дүнг бодит үзлэг болон шинжилгээний үр дүнгээр хянаж үнэлэв. Судалгааны дүнгээс харахад Хөхөн-1 эм нь эмэгтэйчүүдийн хөхний булчирхайн гиперплазийн үед өвдөлт намдаах, хөхний булчирхай томрохыг бууруулах, илрэх шинж тэмдгүүдийг бууруулах нөлөө үзүүлж байна.

Үндэслэл: Монгол анагаах ухаанд цус бүрэлдсэн өвчин бол бүх биеийн чанартай эмэгтэйн ерөнхий өвчин бөгөөд өвчин үүсэх шалтгаан, өвчний явц, шинж тэмдэг, оношилгоо, эмчилгээний талаар нэлээд туршлага хуримтлуулсан байдаг. Сүүлийн жилүүдэд монгол эмч нарын эмчилж байгаа хөхний булчирхайн гиперплази өвчин нь Монгол анагаах ухааны онолоор эмэгтэйчүүдийн цус бүрэлдсэн өвчний нэг зүйл болох бөгөөд эмчилгээний үр дүн сайтай байгаа гэсэн судалгаанууд гарчээ. Монгол анагаах ухаанд тус өвчнийг: “Эмэгтэйн хөхөнд адил бус тоо хэмжээний хатуу бөөм хэсэг бүрэлдэх өвчин гэх бөгөөд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд олон тохиолдоно“ гэжээ. Шалтгаан нь бадган, хий, цус байна. Үүнд хүнд тослог хүйтэн чанартай, муудсан идээ ундааг хэтрүүлэх, хүйтэн чийгэнд даарч жиндэх зэрэг хүйтний нөхцлөөс ходоодны галын илч нь доройтож, бадган салс арвидаад, хий цусны гүйх мөрийг хааж, хөхний булчирхайн сүвнүүд нь бөглөрснөөс бөөгнөрөн хатуурах, эсвэл хурц халуун чанартай идээ ундааг хэтрүүлэх, гал наранд халах, халуун газар унтах, хатуу хүчлэх, хэтэрхий уурлах зэргээр цус шарыг арвидуулж, элгэнд цусан халуун үүсгээд тунгалаг эс шингэж, хөхөнд муу цус хурж бүрэлдэх буюу цөвүүд нь тунгалгийн гүйх мөрийг хааж, хөхний булчирхайн сүвүүд нь бөглөрснөөс бөөгнөрөн хэсэгрэх, эсвэл хэтэрхий гуниглаж гутрах, сэтгэл санаа зовох зэргээр хий арвидаж хямраад, хөхний булчирхайд хий хуйлран зангирч, хий цусны гүйдэл нь доройтон удааширснаар хөхний булчирхай нь бөөгнөрөн хэсэгрээд тус өвчинг үүсгэнэ.[1-4]

Хөхний булчирхайн гиперплази өвчин (Олон улсын өвчний ангиллаар (ICD-10) N60.0-N60.9) бол хөхний булчирхайн дамжуулах гуурс нь өргөсөх, ширхэглэг эд нь өсөх гол шинж тэмдэг бүхий, практикт залуу болон дунд насны эмэгтэйчүүдэд олон тохиолддог. Энэ нь хүмүүсийн амьдралын хэв маяг, хоол ундны бүтэц найрлага өөрчлөгдөх, уур амьсгал, орчин тойрон зэрэг нөхцлөөс болж өвчлөлийн тохиолдол жил бүр 2.7 дахин нэмэгдэж байна. Эмнэлзүйд илрэх гол шинж тэмдэг нь өвдөх, хавдар үүсэх, хэмжээ нь адилгүйгээс болж илрэх шинж тэмдэг нь өөр өөр байдаг. Энэ нь өвчтөнд маш их сэтгэл санааны дарамтыг бий болгож, цаашдаа хөхний булчирхайн хорт хавдар болж хувирах нь эрүүл эмэгтэйчүүдээс 1.4–1.5 дахин өндөр байна.[5]

Монгол эм, эмнэлгийн практикт (Өвөр Монгол) хөхний булчирхайн гиперплази өвчнийг хөхөн -1 (дөрвөлж өвс, чацаргана, олмосэ, урт хошуут ар үр, гүргэм, рүда, цагаан гаа, барагшин, цусан эвэр, хорхой мөөг зэргээр голлосон 30 хөл эмтэй) эмээр 30

гаруй жил эмнэн засаад үр дүн сайтай нь болох нь харагдсан.[6] Тус эм нь цусны гүйдлийг сайжруулан, бэтэг хавдрыг хайлуулах, хурж бөөгнөрснийг тараан зохицуулах, махбодыг тэгшитгэн, тунгалаг цөвийн ялгаралтыг сайжруулах чадалтай. Тиймээс бид хөхний булчирхайн гиперплазийн эмгэгт Хөхөн-1 эмийн үзүүлэх нөлөөг судлахаар сонгон авлаа.

Зорилго: Хөхний булчирхайн эмгэгийн үед хэрэглэдэг Хөхөн-1 монгол эмийн эмнэлзүйн судалгаа хийж үр дүнг тооцох

Материал арга зүй: Судалгааг ӨМҮИС-ийн Харьяа Эмнэлгийн Хороог түшиглэн санамсаргүй хуваарьлалттай эмнэлзүйн туршилт судалгааны зэрэгцүүлсэн загвараар явуулав. Судалгаанд ӨМӨЗО-ны ӨМҮИС-ийн Эмийн үйлдвэрт үйлдвэрлэсэн хөхөн-1 эмийг (дугаар:9604-79) (400мг/кг тунгаар өдөрт 1 удаа) ашиглав. Харьцуулах бүлэгт БНХАУ-д үйлдвэрлэсэн Шиа Кү Цаү Xia Ku Cao (批准文号国药准字 Z19991033) эмийг (300мг/кг тунгаар өдөрт 1 удаа) ашиглав.

Судалгаанд хамруулах шалгуурын дагуу үйлчлүүлэгчийг сонгон авч судалгааны бүлэгт (n=40) монгол эм хөхөн-1, харьцуулах бүлэгт (n=40) хятад эм Xia Ku Cao хэрэглэн 3 ба 6 дахь долоо хоног бүр эмчилгээний үр дүнг бодит үзлэг болон шинжилгээний үр дүнгээр хянаж үнэлэв.

Эмчилгээний үр дүнг шалгахдаа “2002 оны БНХАУ-ын Мэс заслын нийгэмлэгийн хөхний булчирхайн өвчний тусгай мэргэжлийн зөвлөлийн VIII хурал” -аас тогтоосон хөхний булчирхай гиперплазийг эмчилсэн эмчилгээний үр дүнг хянах ерөнхий аргачлалын дагуу томъёогоор тооцов.[7]

$$\text{Эмчилгээний үр дүн (n)} = \frac{\text{эмчлүүлэхээс өмнөх ерөнхий оноо} - \text{эмчлүүлсний дараах ерөнхий оноо}}{\text{эмчлүүлэхээс өмнөх ерөнхий оноо}} \times 100\%$$

Бүрэн эдгэрсэн: Үр дүнгийн харьцаа ≥90%
Эдгэрсэн: Үр дүнгийн харьцаа70% - 89%
Сайжирсан: Үр дүнгийн харьцаа 30% - 69%
Эдгэрээгүй: Үр дүнгийн харьцаа <30%

Хөхний булчирхайн томролын зэргийг БНХАУ-ын Мэс заслын Нийгэмлэгийн 2002 оны хурлаар баталсан хөхний гиперплазийн хүнд хөнгөний зэргийн ангилал ашиглаж онооны системээр дүгнэн тогтоов. Үүнд хөхний булчирхайн томорсон хэсгийн шинж чанар, хүрэлцэхэд өвдөх байдал, бөөн хэсгийн хүрээ хэмжээ, өвдөлтийн зэрэг, сэтгэл санааны байдал, цээж дүүрч давчдах шинж, сарын тэмдгийн байдал зэргээр үнэлэв.[8,9]

Эмнэлзүйн судалгааг хийхдээ ДЭМБ-аас гаргасан “Эмийн эмнэлзүйн судалгааны удирдамж, ЭМС-ын 223 тоот тушаалын нэгдүгээр хавсралт болох “Биоанагаах ухааны судалгаанд хүнийг хамруулах ёсзүйн удирдамж” (2012)-ийг мөрдлөг болгон зохих зөвшөөрлийн дагуу судалгааг явуулав. Эмнэлзүйн судалгаанд оролцогсдыг сайн дурын үндсэн дээр хамруулж, таниулсан зөвшөөрлийн хуудсаар баталгаажуулав.

Үр дүн:

Судалгаанд оролцогчдын биеийн үндсэн үзүүлэлтүүд: Судалгаанд нийт 80 хүн хамрагдсан бөгөөд хамгийн ахмад нь 50 настай, хамгийн залуу нь 23 настай нь дундаж нас 35.78 байв. Өвдсөн хугацааг харьцуулж үзэхэд хамгийн урт нь 14 жил, хамгийн бага нь өвдөөд 3 сар буюу дундаж өвдсөн хугацаа 2.27 жил байна.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын нас, өвдөлт үргэлжилсэн хугацааг харьцуулсан дүн

Эмчилгээний бүлгүүд	Нас (жилээр)			Өвдсөн хугацаа (жилээр)			
	18-30	31-40	41-50	< 1	1 ~	2 ~	3<
Хөхөн-1 /n=40/	6	19	15	6	17	6	11
Xia Ku Cao/n=40/	8	21	11	11	14	8	7
p-утга		1.0‡			2.94†		

Тайлбар: † үл хамааралт t-test, ‡x2 test

Судалгаанд хамрагдсан хоёр бүлгийн хүмүүсийн насны тархцын байдал, (p=1.0). өвчилсөн хугацааг харьцуулж үзэхэд ялгаа байсангүй (p=2.94).

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын эмчилгээний үр дүнг харьцуулсан дүн

Эмчилгээний бүлгүүд	эдгэрсэн		нэлээд сайжирсан		сайжирсан		эдгээгүй		Ерөнхийдөө тусалсан	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хөхөн-1 /n=40/	8	20	24	60	6	15	2	5	38	95
Xia Ku Cao /n=40/	3	7.5	15	37.5	19	47.5	3	7.5	37	92.5
p-утга										

Тайлбар: X2 = 11.31; p <0.05

Хөхний гиперплазийн хүнд хөнгөний зэргийг тогтооход судалгаанд оролцогчдын хувьд 8-14 оноо буюу хөнгөн, 15- 21 оноо буюу дунд зэрэгтэй байв. Эмчилгээний дараа Хөхөн- 1 эмийн бүлэгт хүндийн зэрэг дунд зэргээс хөнгөн зэрэг болж буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Хөхний булчирхайн томролын зэргийн шинж тэмдгийг үнэлсэн дүн

Шинж тэмдэг	Эмчилгээний бүлгүүд	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа	Бүлэг доторх р утга	Бүлэг хоорондох р утга
Хөхний булчирхай өвдөх *	Хөхөн-1/n=40/	6.53±1.65	0.83±1.36	2.25E-22	0.0006
	Xia Ku Cao /n=40/	6.38±2.17	2.10±1.82	3.78E-14	
Бөөн хэсгийн Их бага **	Хөхөн-1/n=40/	1.75±0.54	0.80±0.56	2.58E-09	0.0397
	Xia Ku Cao /n=40/	1.53±0.69	1.05±0.50	5.06E-09	
Бөөн хэсгийн хүрээ хэмжээ	Хөхөн-1/n=40/	1.7±0.65	0.80±0.61	8.65E-10	0.1178
	Xia Ku Cao /n=40/	1.75±0.81	1.10±0.67	1.55E-05	
Хүрэлцэхэд өвдөлттэй эсэх	Хөхөн-1/n=40/	1 ± 0	0.05±0.22	4.06E-26	**0.0781**
	Xia Ku Cao /n=40/	1 ± 0	0.18±0.38	9.47E-16	
Бөөн хэсгийн шинж чанар	Хөхөн-1/n=40/	1.93±0.47	0.38± 0.54	1.63E-16	0.0786
	Xia Ku Cao /n=40/	1.83±0.51	0.65±0.66	2.61E-14	
Уурлаж Бачимдах	Хөхөн-1/n=40/	1.71±0.64	0.13±0.33	1.56E-17	0.1008
	Xia Ku Cao /n=40/	2.03±0.71	0.32±0.50	1.75E-13	
Цээж дүүрч Бухимдах	Хөхөн-1/n=40/	1 ± 0	0.03±0.16	7.84E-31	0.1045
	Xia Ku Cao /n=40/	1 ± 0	0.10±0.30	7.05E-15	
Сарын тэмдгийн байдал	Хөхөн-1/n=40/	0.63±0.49	0 ± 0	7.82E-10	0.1559
	Xia Ku Cao /n=40/	0.5±0.51	0.05±0.22	1.59E-06	

Тайлбар: Mean±SD; *p<0.05, ** p<0.05

Хүснэгтээс харахад эмчилгээний дараа хөхний булчирхай өвдөх, бөөн хэсгийн их бага зэрэг шинж тэмдгийг засахдаа хөхөн-1 эм хэрэглэсэн бүлэгт харьцуулах Xia Ku Cao эм хэрэглэсэн бүлгээс илүү сайжирсан үзүүлэлттэй байна (p<0.05).

Судалгааны нөхцөл байдлаас шалтгаалан судалгааны хөхөн-1 эм хэрэглэж байгаа бүлгийн 26 эмэгтэйчүүдэд шар биеийн хугацаан дахь бэлгийн дааврын хэмжээг судалгааны өмнө болон дараа тодорхойлж үзлээ.

Хүснэгт 5. Судалгаанд оролцогчдын зарим дааврын түвшинг тодорхойлсон дүн

Даавруд	Эм хэрэглэхийн өмнө	Эм хэрэглэсний дараа	F/P
E2 (pg/ml)	89.44 ± 23.04	58.86 ± 16.57	F= 30.19 P < 0.05
P (pg/ml)	13.38 ± 3.79	12.9 ± 3.8	F = 2.55 P > 0.05
PRL (pg/ml)	13.27 ± 2.35	9.89 ± 1.75	F = 34.75, P < 0.05
E2 / P	7.02 ± 2.62	5.32 ± 2.02	

Эстрадиал дааврын хэмжээ эм хэрэглэсний дараа статистик ач холбогдол бүхий буурсан байна (F=0.19, p<0.05). Прогестрон дааврын хэмжээг судалгааны өмнө болон дараа харьцуулж үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа илрээгүй (F=2.55, p>0.05). Пролактин дааврын хэмжээг судалгааны өмнө болон дараа харьцуулж үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаатай буурсан байна (F=34.75, p< 0.05).

Хэлцэмж: Монгол анагаах ухаанд хөхний булчирхайн гиперплази өвчнийг эмчлэхдээ хий цусны гүйдлийг сайжруулж, хурж бөөгнөрснийг тархаахаар урьдал болгон, тунгалаг цөвийн ялгаралтыг сайжруулах ба илчийг сэлбэх, махбодыг тэгшитгэх зарчмыг анхааран эмчлэх зарчим баримталдаг.[1-4]

Сүүлийн жилүүдэд, хөхний булчирхайн гиперплази өвчний тохиолдол нэмэгдэж, нас нь ч залуужих хандлагатай байна. Хэдийгээр маш олон шинэ эм нээгдэж гарч байгаа боловч, зарим химийн эмийн бодис нь гаж нөлөө их учраас эмчилгээнд удаан хугацаагаар хэрэглэж болдоггүй. Хөхөн-1 эмийн найрлагад орж байгаа ургамал, амьтан, эрдсийн гаралтай түүхий эдүүдийн дийлэнх нь гашуун амттай, хийг дарах, цусны гүйдлийг сайжруулах, үрэвсэл дарах зэрэг үйлдэлтэй чадлаар найрагдсан эм байна. Хөхөн-1 эм нь нэгдүгээрт хөхний булчирхай томрох өвчний шалтгаан, өвчин зүйг үндэслэж, тусгай найруулсан найрлага юм. Цусны гүйдлийг сайжруулан, бэтэг хавдрыг хайлуулах, хурж бөөгнөрснийг тараан зохицуулах, махбодыг тэгшитгэн, тунгалаг цөвийн ялгаралтыг сайжруулах чадалтай. Хоёрдугаарт өвчний махбодын байдал, өвчний хүнд хөнгөн, халуун хүйтэн зэргийг үндэслэж тус найрлагаар гол болгож тухайн байдалтай уялдуулан эмчилдэг. Гуравдугаарт тус найрлагыг зохиохдоо Монгол анагаах ухааны үндсэн онолыг удирдамж болгохын зэрэгцээ, орчин үеийн анагаах ухааны онолын үзэл баримтлалыг давхар анхаарч уялдуулан найруулсан байна.[10-13]

Судалгааны үр дүнгээс харахад Хөхөн-1 эм нь хөхний булчирхай томрох өвчний үед өвдөлт намдаах, хөхний булчирхайн томорсныг бууруулах, илрэх шинж тэмдгийг бууруулах нөлөөтэй байна. Тус эм нь хөхний булчирхайн эдийн дааврын хэмжээг багасгах буюу эсвэл дааврын рецептор нь эстрадиолтой нийлэхийг хориглосноор хөхний булчирхайн эдийн эстрадиолын мэдрэг чанарыг бууруулан эм бэлгийн дааврыг эсэргүүцэж, хөхний булчирхай хэт томрохыг эмчлэх үйлдэл үзүүлж байна гэж үзлээ.

Дүгнэлт: Хөхөн-1 уламжлалт эм нь эмэгтэйчүүдийн хөхний булчирхайн гиперплазийн үед өвдөлт намдаах, хөхний булчирхай томрохыг бууруулах, илрэх шинж тэмдгүүдийг бууруулах нөлөө үзүүлж байна.

Ном зүй:

1. *Ютиг Ёндонгомбо. Анагаах ухааны дөрвөн үндэс. Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хороо. 1987.*
2. *Сүрэнжав. Дотор өвчин судлал. Өвөр Монголын үндэсний хэвлэлийн хороо. 1986:483-487*
3. *Дэсрид Санжаажамц. Увдисын үндэсний нэмсэн арга. Өвөр Монголын үндэсний хэвлэлийн хороо. 1992;х.11, 879*
4. *Дармамаарамба Лувсанчойрог.Алтанчимэг. Өвөр Монголын үндэсний хэвлэлийн хороо. 1987*
5. *Lin Yi, Tang Hanjun. Gynecology of modern Chinese medicine. Beijing: People's health publishing house.2003.5:103-104*
6. *Erdu, Xiulan, Bao Luming. Observation on the curative effect of mammary gland no.1 in the treatment of 400 cases of cystic hyperplasia of mammary gland. Journal of Inner Mongolia University for Nationalities, 2005, 20 (6):704*
7. *Wu Zai De Wu Zhao-Han. Surgery version 7. People's medical publishing house. 2008.4:307*
8. *Xu Fangfang, Wang Qun. Research progress of animal model building methods for HMG disease.*
9. *Proceedings of the academic conference on integrated traditional Chinese and western medicine on breast diseases, 2011*
10. *Chen Zhichun, Duan Xiaobo, Hu Zhihua, et al. Chinese pharmacology bulletin, 1991,7(2):156.*
11. *Багана нар. Монгол анагаах ухааны эм найрлагын судлал. ӨМӨЗО.Хөх хот. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2007:86-87*
12. *Монгол анагаах ухааны найруулах зөвлөл. БНХАУ-ын анагаах ухааны нэвтэрхий толь. Монгол анагаах ухаан. Шанхай. Шанхайн шинжлэх мэргэжил хэвлэлийн хороо. 1992:240*
13. *БНХАУ-ын Эрүүл хамгааллын яамны эмийн толийн зөвлөл. БНХАУ-ын ЭХЯ-ны эмт бодисын баримжаа. Монгол эмийн хуваарь боть.1998:376*

Clinical study to evaluate the effects of RuXian-I medicine the patients with hyperplasia of mammary gland.

Zhao Shuang Quan[1], Chimedragchaa Ch[2], Jambaldorj J[3], Alimaa T[1]

[1]International School of Mongolian Medicine, MNUMS
[2]Institute of Traditional Medical Technology
[3]School of Biomedicine, MNUMS
Email: 13154898993@163.com, Tel:96655004

Hyperplasia of mammary gland (HMG) is a common breast diseases in the middle-aged women all over the word and a precancerous lesion of mammary gland (MG).

The traditional Mongolian medicine RuXian-I provided by the Affiliated Hospital of Inner Mongolia University for Nationalities is an empirical formula specifically to use for the treatment of HMG in clinical based on the principles of traditional Mongolian medicine. RuXian-I is composed of 30 ingredients, which are Herba Leonuri Japonici, Fructus Amomi Rotundus, Flos Caryophylli, Fructus Gardeniae, Rhizoma Gymnadeniae Conopseae, Semen Myristicae, Cornu Cervi Pantotrichum, Cordyceps and so on. These herbs themselves have a variety of biological activities, including anti-allergic, anti-oxidant and anti-tumor, anti-inflammation activity. The aim of this study was to evaluate the effects of Mongolian medicine RuXian-I treatment patients with hyperplasia of mammary gland.

The clinical trial was carried out at Afhliated hospital of National University of Inner Mongolia, with two parallel groups: a RuXian-I and a Xia Ku Cao. The data's were analyzed at the baseline, during the 3 and 6 weeks of follow-up by repeated measures analysis of variance. During follow up, the assessments scores of symptoms were significantly decreased to pre-treatment level in both group. RuXian-I medicine reduce the pain and decrease the hyperplasia of mammary gland in patients with hyperplasia of mammary gland.

Keywords: RuXian-I medicine, breast hyperplasia, clinical trial